

“МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦАА, ТУСГААР ТОГТНОЛЫН АСУУДАЛД / 1945-1961/”

Доктор. проф. Д.Өлзийдолгор

Доктор (PhD) дэд. проф. Д. Наранцэцэг

Аливаа улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнолын асуудал ямагт төрийн бодлогын онцгой анхаарлын төвд тавигдаж байдаг. Манай улсын ХХ зууны түүхийн нэгэн чухал зурвас үе эл асуудалтай салшгүй холбоотой ирсэн. Хэдийгээр Монгол Улс өнөөдөр тусгаар тогтносон, бүрэн эрхт улс мөн боловч түүний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа нь чухам юу болох вэ? гэдэг талаар олон маргаан түүхчид, улс төрчдийн дунд явагдсаар байна. “Сайн засаглал уу?”, “Хүчирхэг эдийн засаг уу?”, “Туравдахь түнш үү?”, “НҮБ үү?”, аль эсвэл “Чадварлаг стратегийн бодлого уу?”, “Тогтвортой хөгжил үү?” гэх зэрэг олон асуултыг дэвшүүлж болох боловч цаашид ч эл асуудлын хариуг олох нь маш чухал зүйл болно. Гэвч монголчууд тусгаар тогтнол, аюулгүй байдлынхаа төлөө хэрхэн тэмцэж ирсэн нь ямагт түүхийн зангилаа асуудлын нэг хэвээр үлдэнэ. Иймд бид дэлхийн хоёрдугаар дайны дараахи жилүүдийн нөхцөл байдлыг нарийвчлан судлах нь ихээхэн ач холбогдолтой болно.

Дэлхийн хоёрдугаар дайн дуусмагц даян дэлхийд энх тайван, аюулгүй байдлыг тогтоох зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллага байгуулагдсан. Дайны дараахи дэлхийн олон улсын нөхцөл байдал, шинээр үүссэн хоёр туйлт систем, түүнд эзлэх их гүрнүүдийн байр суурь, нэг ёсны өрнөсөн “нөлөөний хүрээ тогтоох тэмцэл” зэрэг нь Монгол улсын тусгаар тогтнолын асуудалтай салшгүй уялдаа холбоотой ирсэн түүхтэй. Иймд Монгол улсын статус-квог хөрш зэргэлдээ болон гадны хүчирхэг улсуудаар хүлээн зөвшөөрүүлэх, Монгол Улсыг дэлхийн олон улсын энэхүү нэр хүндтэй байгууллагад элсүүлэх замаар дэлхийн тавцанд гаргах асуудал нэн чухал асуудлуудын нэг болж тавигдсан. Монгол Улсын статус-квог АНУ-аар хүлээн зөвшөөрүүлэх асуудал 1945 оны хоёрдугаар сард хуралдсан Ялтын хурал дээр (2.6.) ЗХУ-ын санаачилгаар анх тавигдаж, дайны дараахи жилүүдийн БНМАУ-ын гадаад бодлогыг тодорхойлох нэгэн хүчин зүйл болж дараахи чухал алхмуудыг хийхэд хүргэсэн нь 1945 оны аравдугаар сарын 20-нд Хятадын засгийн газрын ажиглагчдын хараанд болж өнгөрсөн санал асуулга байв. 1946 оны 1-р сарын 5-нд санал асуулгын дүнтэй танилцсаны үндсэн дээр Гоминданы Хятад БНМАУ-ын бүрэн эрхт байдлыг хүлээн зөвшөөрсөн билээ. Удаалан мөн оны 6-р сарын 24-нд БНМАУ НҮБ-д элсэх өргөдлөө албан ёсоор өргөн барьсан юм. Гэвч зөвхөн 15 жилийн дараа БНМАУ НҮБ-ын албан ёсны гишүүн орон болж чадсан. Монгол Улсын гадаад харилцаа, тусгаар тогтнолын асуудлыг 1945 - 1961 оноор онцлон үечилсэн явдал, энэ

хугацаанд баримталж ирсэн гадаад бодлогын үндсэн зорилго ч манай орныг НҮБ-д элсүүлэх тэмцлийн ерөнхий хүрээнд явагдсан.

1945 оны хоёрдугаар сард хуралдсан Ялтын гурван их гүрний тэргүүн нарын бага хурал дээр ЗХУ хэд хэдэн болзол тавьсны үндсэн дээр Японы эсрэг холбоотнуудын талд байлдах саналаа өгсөн. Эдгээр болзлуудын нэг нь БНМАУ-ын олон улсын эрх зүйн статусыг тусгаар тогтносон бүрэн эрхт улсын хувьд хүлээн зөвшөөрүүлэх явдал байв. АНУ, Англи хоёр үүнийг хүлээн авсан ба "Алс Дорнодын талаархи гурван улсын" хэлэлцээрт /1945 оны 2-р сарын 11-нд тус хуралдаан дээр гарын үсэг зурцгаасан/ "...Гадаад Монголын Status quo-г хэвээр хадгална гэж заасан байв. Түүнчлэн дараахи нэг болзлын дагуу Ялтын хэлэлцээрээр АНУ-ын засгийн газар нь Чан Кай Шиг БНМАУ-ыг хүлээн зөвшөөрүүлэх талаар бололцоотой бүхнийг хийх болно хэмээн амлалт авчээ (2.6).

ЗХУ ямар ч санаа агуулж байсан гэлээ гэсэн Монголын статус-квог одоо байгаа хэвээр батлах гэсэн холбоотон гүрнүүдийн энэ зөвшилцөл БНМАУ-ын тусгаар тогтнолд томоохон алхам болсныг өнөөдөр үгүйсгэж болохгүй юм. Нөгөө талаас ЗХУ, БНМАУ-ыг Өвөр Монголтой нэгтгэхээс болгоомжилдог байсан нь хоёр Монголын нэгдэл ЗХУ-д саад болсондоо биш, Хятадтай илүү маргаан дэгдээхийг хүсээгүйтэй холбоотой болов уу. Учир нь Монгол үндэстний нэгдсэн гэр улсыг байгуулах тухай өөрийн бодлыг Х. Чойбалсан Сталинд хэд хэдэн удаа болгоомжтойгоор дурдахад ЗХУ-ын тэргүүн нааштай хандсан үг хэлж байсан түүхтэй.

Ялтын бага хурал дээр хэдийгээр Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх асуудал ийнхүү тавигдсан ч түүний дараа долдугаар сард болсон ЗХУ – Хятадын хоорондын төрийн дээд хэмжээний уулзалт нь хоёр улсын хоорондын харилцааг сайжруулах үндсэн зорилгыг агуулахын сацуу, хоёр улсын аль алиныхаа сонирхлыг хөндсөн өөр чухал асуудлуудыг хөндсөн тухай мэдээлж байв (3.15). Тухайн уулзалт нь Сталин, Молотов нарыг гурван улсын тэргүүн нарын уулзалтанд явах болзонттой холбогдон түр тасарджээ. Сталиныг Берлины хуралдаанаас хүрэлцэн ирсний дараа Хятадын ерөнхий сайд ноён Сун Цзы Вень Москвад хүрэлцэн ирснээр хэлэлцээрийг дахин үргэлжлүүлж 1945 оны наймдугаар сарын 14-нд "ЗХУ ба Хятад улсын хооронд найрамдал, хамтын үйл ажиллагааны тухай" гэрээ байгуулагдсан юм. (4.1.) Тухайн гэрээ байгуулагдах үеэр ч мөн БНМАУ-ын тусгаар тогтнолын асуудал хөндөгдөн тавигдсан байх талтай.

Хятад БНМАУ-ын статус-квог батлах дургүй байсныг дараахи баримтаас харж болох юм. "Сан-Францискогийн бага хуралд сууж байсан гүйцэтгэх Юанийн дарга Сун Зивэн америкчуудтай уулзаж "Гадаад Монголын статус-кво"-г юу гэж ойлгох талаар ярилцан БНМАУ өөрийгөө тусгаар тогтносон улс гэдэг боловч Хятад зөвшөөрдөггүй ба ЗХУ түүнийг Хятадын газар нутгийн салшгүй нэг хэсэг гэж хүлээн зөвшөөрдөг. Гэвч Гадаад Монгол Хятадын хооронд харилцан зохицолдоо үгүй боловч ямар нэг зөрчилдөөн гараагүй байдлыг л Монголын статус кво гэж ойлголцож байгаагаа илэрхийлцгээжээ.

Үүний дараагаар Хятадын төлөөлөгчид ЗХУ-ын удирдлагатай уулзаж мөн л асуудлаа тавихад И.В. Сталин Гадаад Монголын эрх ашгийг хамгаалж байгааг нуулгүй хэлсэн юм. Хятад БНМАУ-ыг өөртөө нэгтгэх гэсэн санаагаа орхиогүй бөгөөд ЗХУ өөрийн байр суурь дээр хатуу зогссоноос Чан Кай Ши буудт хийж, хэрвээ Гадаад Монголын ард түмэн санал асуулгаар тусгаар тогтнолынхоо төлөө саналаа өгөх юм бол Хятад улс түүний тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрнө гэсэн болзол тавьжээ. Хэдийгээр санал асуулгын үр дүнгийн дагуу Гоминданы Хятад амалсан ёсоороо БНМАУ-ын сатус квог хүлээн зөвшөөрсөн ч БНМАУ-ыг нэгтгэх гэсэн эл саналыг Гоминданы байр суурийг эзэлсэн Хятадын засгийн газар үргэлжүүлж байсан нь дараахи баримтаас харагдана.

1949 онд Хятадад ЗХУКН-ын ТХ-ны гишүүн, ЗХУ-ын СнЗ-ийн орлогч дарга А.И. Микоян айлчилж Мао-Зэдун, Лю-Шаоци, Жоу-Эньлай нартай хэлэлцээ хийхдээ долоон сэдвээр хэлэлцээ хийсний зургаа дахь нь БНМАУ-ын тухай асуудал байлаа. БНМАУ-ын талаархи ярианы сэдвийг Мао-Зэдун эхэлж хөнджээ. Хоёр Монголыг нэгтгэх асуудлыг ЗХУ хэрхэн үзэж байгааг тэрээр маш болгоомжтойгоор сонирхон асуужээ. ЗХУ-ын дипломат М.С. Капица "Хятадын л газар нутгаас хорогдох байх даа" хэмээн хариулснаараа уг асуудлын талаархи ЗХУ-ын байр суурийг тодорхойлсон юм. Мао-Зэдун хоёр Монгол нэгдээд Хятадын бүрэлдэхүүнд орж болох тухай өөрийн байр суурийг мөн тодорхойлжээ.

БНМАУ-ын асуудлаар И.В.Сталин М.И.Капицад илгээсэн цахилгаандаа "...Монголын удирдлага Хятадын Монгол районыг Ар Монголтой нэгтгэн нэг Монголыг байгуулахыг хүсэмжилж байгаа нь ЗХУ-ын сонирхолд огтхон ч харшлаагүй ч ЗХУ БНХАУ-ын газар нутгаас тасалж авахыг зөвшөөрөөгүй. Хятадын автономит болж нэгдэхийг Ар Монгол зөвшөөрөхгүй биз дээ. Гэхдээ эцсийн үгийг Ар Монгол л хэлнэ шүү дээ ..." хэмээн байр сууриа тодорхойлжээ. Энэ нь Ялтын бага хурлаар хоёр Монголын хувь заяаг шийдвэрлэхэд ЗХУ-ын баримталсан тэр байр суурь мөн байлаа. Сталины цахилгааныг Мао-Зэдун уншаад "...Би Их Хятадын шовинист үзлийг хамгаалахгүй байгаа болохоор хоёр Монголыг нэгтгэх тухай асуудлыг дахин хөндөхгүй" гэсэн ч БНМАУ-ын талаархи өөрийн байр суурийг хатуу баримталсаар байжээ.

1949 оны арванхоёрдугаар сарын 16-нд Мао-Зэдунг ЗХУ-д айлчлахдаа Ар Монголын тухай ямар нэгэн ярианаас илт зугтаахад нь Гадаад яамны сайд В. Молотов Монголын талаархи өмнөх хэлэлцээрийг зөрчлөө хэмээн ихэд уурлаж байжээ. Тус хоёр орны Гадаад явдлын яамны сайд нар 1945 оны наймдугаар сарын 14-нд Хятад, ЗХУ-ын хооронд хийсэн Гадаад Монголын тухай гэрээгээ цуцалж БНМАУ-ын бүрэн эрхт байдлыг хоёр тал хүлээн зөвшөөрнө гэсэн ноот бичиг солилцжээ (4.1.). 1950 оны хоёрдугаар сарын 14-нд "ЗХУ ба БНХАУ-ын найрамдал, хамтын харилцан туслалцааны тухай" гэрээ байгуулагдсан боловч мөн энэ үеэр Монголын асуудал хөндөгдөн яригдсан гэж үздэг. Ялангуяа 1950-иад оны дунд үеэс Монгол-Хятадын хоорондын харилцаа муудаж эхлэх тэр мөчид Хятадын Засгийн Газар Монголыг Хятадад нэгтгэх асуудлыг дахин дахин хөндөж шахалт үзүүлж эхэлсэн ба түүнийгээ албан ёсоор 1954 онд ЗХУ-ын

төлөөлөгчид Бээжинд айлчлах үеэр Мао Зэдун хөндөн тавьсан байдаг. Үүний хариуд ЗХУ-ын төлөөлөгчид уг асуудлыг хэлэлцэхээс татгалзаж "БНМАУ-ын хувь заяаны асуудлыг Бээжин, Москвад бус харин Улаанбаатарт шийдэх ёстой..." хэмээн тэмдэглэж байжээ.

Ийнхүү хоёр том гүрний дунд оршиж ирсэн Монгол улс нь ямагт эл хоёр улсын маргааны төв болж, хоёр улс хоёулаа тухайн газар нутаг, ард түмэн дээр нөлөөгөө тогтоох сонирхолтой байсан. Эл сонирхол нь хоёр улсын улс төр, эдийн засаг ба стратегийн асуудлаас улбаатай байсныг харуулж байгаа юм. Чухамхүү энэ хүнд эдрээтэй мөчид БНМАУ НҮБ-д элсэх тэмцлээ тасралтгүй үргэлжлүүлж байлаа. Монгол Улсын тусгаар тогтнолын асуудал аюулд тулгарах нь болзошгүй байсан бөгөөд / зөвхөн Хятадын аюул бус, мөн ЗХУ-ын зүгээс гарч байсан аюул / түүнийг НҮБ-ийн гишүүн орон болгох нь монголчуудын хувьд нэг ёсны "хамгаалалт" болох байсан гэж үзэж болно. Өнөөдөр бид энэ тэмцэл хэрхэн өрнөсөн тухай өгүүлэх бус харин /1946 оноос хойш 1948, 1955, 56, 57, 60 онуудад БНМАУ НҮБ-д элсэх өргөдлийг удаа дараалан өгсөн/ ямар шалтгаанаар түүнийг энэ удаан хугацааны турш чөдөрлөн барьж байсан, ямар хүчин зүйлс үүнд нөлөөлсөн талаар зарим нэг дүгнэлтийг архивын баримтад тулгуурлан хийхэд ЗХУ, АНУ, Гоминданы Хятадын энэ асуудлаар эзэлсэн байр суурь тодхон гарч ирдэг. Ямарч байсан НҮБ-ын түгээмэл зарчимд тулгуурлан 1946 онд анх өргөдлөө өгсөн найман улсыг нэгэн зэрэг элсүүлэн авах АНУ-ын саналыг ЗХУ-ын төлөөлөгчид эсэргүүцсэнээр БНМАУ НҮБ-д элсэн орох боломжоо алдсан юм. Энэ тухайд манай ахмад дипломатч Барнууд Л. Чойжилсүрэн дурсан тэмдэглэхдээ: "Ардчилсан" улсууд гээд хуруу даран тоолбол ердөө л аравхан орон байгаа юм чинь. Америкийг нааштай хандаж байгаа дээр Албани, Монгол хоёрыг дэмжээд оруулъя гэж Громыко гуай боддоггүй юм байх даа (7.46) гэсэн байдаг.

Түүнчлэн БНМАУ-ын талаар шаардсан үндсэн 4 асуудал бүхий мэдээллийг НҮБ-ын АЗ-ийн хуралдаанд танилцуулах явцад манай төлөөлөгчдийн авч явсан бичиг баримтанд урьдчилан хийсэн Зөвлөлтийн засвараас /"Молотовын засвар"/ болж БНМАУ-ын баримталж буй гадаад бодлого, түүний дэлхийн улс орнуудтай дипломат харилцаа тогтоох хүсэл эрмэлзэл, шаардлага хийгээд НҮБ-д элсэх хүсэл сонирхол, зорилго зэрэг нь нэн ойлгомжгүй байна гэсэн дүгнэлтийг хийхэд хүргэжээ (1.11).

Түүнээс хойшхи жилүүдэд ч мөн хэд хэдэн улсын санаачилгаар олон хувилбарууд дэвшигдэж / Канадын, Африкийн 11 орны, Молотовын, г.м. / асуудлыг нааштай шийдэх боломж тавигдаж байсан ч энэ удаад саад тотгорыг АНУ, Хятад, ЗХУ -ын аль аль тал нь бодлого тавьсан гэж үзэх ёстой. БНМАУ НҮБ-д элсэх асуудалд сөргөөр нөлөөлсөн гадаад хүчин зүйлсийн зөвхөн нэг хэсгийг дурдвал, дэлхийн хоёрдугаар дайны дараа өрнөсөн "хүйтэн дайн" нь үнэнхүү НҮБ-ын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж нэг ёсны НҮБ нь хоёр системийн хооронд өрнөсөн энэ тэмцэл зөрчлийн нэгэн талбар болж хувирсан нь зохих нөлөөгөө үзүүлсэн хийгээд НҮБ өөрөө түгээмэл зарчмыг зөрчиж эхэлсэн зэрэг явдал болно.

Харин БНМАУ-ыг НҮБ-д элсэхэд 15 жилийн турш БНМАУ-ын төр засаг хийгээд гадаад орнуудад улс орноо төлөөлөн суугаа дипломатуудын явуулж ирсэн бодлого, хүчин зүтгэл зэргийг бодитойгоор үнэлэх нь зүй ёсны хэрэг мөн.

1961 оны аравдугаар сарын 27 нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1043 дугаар бүгд хуралдаан дээр БНМАУ-ыг НҮБ-ын албан ёсны гишүүнээр элсүүлэн авах шийдвэр гарсан тэр мөчөөс улс орноо дэлхий нийтэд таниулах, хүлээн зөвшөөрүүлэх, дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд тусгаар тогтносон бүрэн эрхт улсын байр сууринаас хүчин зүтгэх бодит нөхцөл бүрдсэн нь БНМАУ-ын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангахад эергээр нөлөөлсөн алхам болсон юм.

Article covers issues of foreign relations and independence of Mongolia between 1945-1961. Authors analysed and revealed positions of J.Stalin, Chang Kaishek (Jiang Jieshi) and Mao Tsedun as a result of Yalta conference and Sino-Soviet friendship treaty of August 1945. Article highlights importance of Mongolia to become member of the UN.

Ном зүй: (Архивын баримтууд)

1. Беседа Молотова с Цеденбалом, Лхамсүреном, и Жаргалсайханом. 24 авг. 1946 / Архив МИД МНР. Ф.61. Оп.2. Д.1. Л.11 /.
2. Материалы Ялтинской конференции. Фонд Международных договорных актов, заключённых СССР с иностранными государствами. / Архив МИД РФ. Ф.№ 0556. Оп.1. Д.7. П.№4.Л.6
3. "Ишибао" О создании автономного правительства во Внутренней Монголии. / Архив МИД РФ. Фонд отдела печати. Оп. 9. Д. № 289. П. 1 136.Л. 15 /
4. "Известия", 15 августа, 1945 г."О Советско-Китайской встрече в верхах" Л. 1. ГХЯ-ны архив. Ф.108.ш.12, х.н. 4
5. Н. Галиймаа. XX зууны Монгол, Америкийн харилцаа : үүсэл хөгжил, тулгамдаж байсан асуудлууд. УБ., 2001. Х., 69-70.
6. Барнууд Л. Чойжилсүрэн. Нью-Йорк 61. УБ., 2001. Х., 42, 46.
7. Тегеран-Ялта-Потсдам. Сб. Документов, Изд-е 2-е. Доп-е. ИМО. 1970. С. 199-200